

Санал гомдлоо илэн далангүй илэрхийлэх

Хэрвээ хэн нэгэн аливаа хууль, Сахилгын дүрэм болон Нийлүүлэгчийн дүрмийг зөрчсөн байж болох сэжиг, таамаглал байвал таныг энэ талаарх санал гомдлоо илэн далангүй илэрхийлээсэй хэмээн бид хүсэж байна.

Бидний зүгээс нээлттэй байдлыг дэмжих бодлого явуулах бөгөөд эдгээр асуудлын талаарх бодлоо илэрхийлэх, буруу байсан ч хамаагүй сэжиг таамаглалаа ярихыг тань хөхиүлэн болно. Гэвч бусдыг гүтгэх зорилгоор илэрхийлсэн гомдол санал сахилгын арга хэмжээ авахад хүргэж болно гэдгийг анхаарна уу.

Сахилгын дүрэм болон Нийлүүлэгчийн дүрмийг www.imperialbrandspkc.com дотоод сүлжээнээс харах боломжтой. Асуулт гарвал Governance.Team@impbrands.com цахим шуудан руу илгээж болно.

Санал гомдлоо илэрхийлэх дараах арга зам байж болно:

1. Орон нутгийн хэмжээнд саналаа илэрхийлэх

Хэрвээ иргэд хариуцсан менежер эсвэл орон нутгийн хүний нөөцийн менежертэй харилцахад танд илүү хялбар байвал тэдгээр ажилтнуудад саналаа илэрхийлж болно.

2. Бүлэгтээ саналаа илэрхийлэх

Орон нутгийн түвшинд саналаа илэрхийлэхэд өөрт тань таатай бус байх эсвэл орон нутгийн түвшинд саналаа илэрхийлсэн ч тэдний авсан арга хэмжээ хангалтгүй санагдвал та Саналын Нууцлалтай Систем-ээр дамжуулан саналаа гомдлоо тавьж болно. Энэ нь найдвартай, нэвтрэх болон ашиглахад хялбар систем бөгөөд саналыг тань шийдвэрлэж чадах, зөв хүмүүст саадгүй дамжуулна. Хэрвээ хүсвэл таны саналыг нэргүйгээр ч дамжуулах боломжтой.

Та <https://imperialbrands.whistleblownetwork.net> сайт руу орон компьютер болон зөөврийн төхөөрөмжөөсөө уг системд нэвтэрч болно. Түүнчлэн төхөөрөмжийнхөө камерыг ашиглан доорх QR кодыг уншуулан нэвтэрч болох юм.



Системд нэвтэрснийхээ дараа та бичгээр саналаа илэрхийлэх буюу дуун зурвас үлдээж болох бөгөөд (одоогоор iOS дэмжих боломжгүй) саналаа баталгаажуулахын тулд зураг, баримт бичиг, видео файлыг мөн хавсаргаж болно. Хэрвээ та дуун зурвасаа нэргүйгээр үлдээхийг хүсвэл танигдахаас сэргийлж дижитал аргаар дууг тань өөрчлөх болно.

Хэрвээ таныг хүсвэл зарим улс оронд үнэгүй утсаар залгаж, цаанаас автоматаар өгсөн зааврын дагуу санал гомдлоо үлдээх боломж бий. Утсаар саналаа үлдээх боломж бүхий улсын жагсаалт болон дугаарыг та эндээс [авч болно](#). Шугамд нэвтэрснийхээ дараа 25492 кодыг хийгээрэй.

Аль ч сонголтыг хийсэн, системээр дамжуулан таньтай холбоо барьж, санал хүсэлтийн чинь хариуг өгөх найдвартай, үр дүнтэй арга хэрэгслийг бүрдүүлсэн Secure Postbox үүсгэхийг урьж байна.

Бидний танд өгөх баталгаа

Ирүүлсэн санал гомдлыг нэргүйгээр байлгах буюу буюу өөрийгөө бусдад таниулахгүй байх хүсэлтийг тань аль болох бүрэн дүүрэн биелүүлэхийг бид хичээх болно. Гэвч санал гомдлын дагуу судалгаа явуулахын тулд зарим нэг мэдээлэл өгөхийг бид танаас хүсэх шаардлагатай болно.

Ажиллаж, амьдардаг газрын тань хууль журамд нийцэж байвал санал гомдлоо нэргүй илэрхийлэх аргыг та сонгож болно.

Санал бодлоо илэн далангүй илэрхийлсэн болон судалгаа хийх явцад тусалсан хүмүүсээс өшөө авах явдлыг бид тэвчдэггүй болно.

2020 оны 11- сар